


Ипотекийн зээлийн тайлан

2014 оны 10 дугаар сар

Банкууд 2014 оны 10 дугаар сард нийт 1953 зээлдэгчид 111.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор банкуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 2703.8¹ тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 63652-т хүрчээ.

Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 8.1 нэгж хувиар, оны эхнээс 75.0 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 63.1 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” (ОСИСТБХ)-ийн хэрэгжилттэй холбоотойгоор 2013 оноос эхлэн эрс нэмэгдсэн байна.



*Нэрлэсэн ДНБ-ийг 2014 оны III улирлын байдлаар авч үзсэн.


Тайлант сарын эцэст банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 70.4 хувь буюу 1903.6 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 8 хувийн хүүтэй зээл болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 27.0 хувь буюу 730 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 2.6 хувь буюу 70.1 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.



¹ МИК-т шилжүүлсэн зээлийн дүн орсноор.

2014 оны 10 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.0 хувь нь төгрөгийн зээл, 2.0 хувь нь гадаад валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2014 оны 10 дугаар сарын байдлаар 2.2 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 0.5 байна.



Тайлант сард олгосон зээл

Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 21.5 хувиар өссөн ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.2 хувиар буурсан байна.



Тайлант сард шинээр олгосон зээлийн 72 хувь буюу 80.6 тэрбум төгрөг нь “Орон сууцны

ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 28 хувь буюу 31.3 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.

Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2014 оны 10 дугаар сарын байдлаар 57.3 сая төгрөг байна.



Тухайн сард 27.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх сараас 1.0 хувиар, оны эхнээс 12.5 хувиар өссөн байна.



Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 1953 иргэн шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 1339 иргэн “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн

тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 614 иргэн банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



2014 оны 10 дугаар сарын байдлаар нийт 63652 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 42772 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 18839 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 2041 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



Зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 0.5-20 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 15.8 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2014 оны 10 дугаар сарын байдлаар 15.1 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 48.7 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 41.9 хувь нь 11-15 жил, 37.7 хувь нь 16-20 жил, 20.8 хувь нь 6-10 жил, 3.4 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.



Зээлийн хүү

Банкуудын 2014 оны 10 дугаар сард олгосон ипотекийн зээлийн хамгийн өндөр хүү нь жилийн 27.6 хувь, хамгийн бага нь 3.6 хувь байсан бөгөөд тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 10.4 хувь байв. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад жигнэсэн дундаж хүү 6.2 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын өөрийн эх үүсвэрээр төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 16.6, валютын зээлийнх 14.2 хувь байв.

Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (сараар)	Тухайн сард олгосон зээлийн ЖДХҮҮ, жилээр (%)	Нийт зээлдэгч (тоогоор)
			ОСИСТГБ хөтөлбөрийн зээл			
2008	12	217,977.5		100.7	19.8	16,522
2009	12	226,040.6		103.4	18.7	16,784
2010	12	333,776.6		115.0	16.0	19,700
2011	12	669,662.8		154.3	14.8	26,869
2012	12	845,204.4		155.5	15.3	29,887
2013	1	856,633.6		149.1	17.0	29,683
	2	873,666.4		156.1	16.8	29,946
	3	903,557.5		158.6	15.7	30,419
	4	944,516.8		155.4	15.8	31,412
	5	986,182.2		147.8	16.6	32,247
	6	1,032,156.7	276,328.4	168.3	12.9	33,028
	7	1,273,003.6	553,346.9	202.4	9.2	37,751
	8	1,461,753.4	781,483.2	207.6	8.9	40,596
	9	1,611,383.8	943,976.7	206.0	9.1	42,968
	10	1,750,781.6	1,076,924.5	193.9	9.6	45,138
	11	1,834,042.7	1,155,409.2	192.8	9.7	46,482
	12	1,938,945.3	1,248,633.8	192.8	9.9	48,320
2014	1	2,021,424.9	1,324,898.9	194.4	9.8	49,731
	2	2,121,802.6	1,382,084.1	193.2	9.9	53,611
	3	2,193,368.6	1,451,938.1	190.7	9.9	54,787
	4	2,280,503.5	1,538,506.8	192.1	9.8	56,137
	5	2,365,349.5	1,618,127.2	189.3	10.0	57,579
	6	2,440,007.1	1,684,583.9	182.3	10.5	58,793
	7	2,492,105.2	1,728,222.8	187.9	10.7	59,756
	8	2,553,827.2	1,780,078.3	186.7	10.5	60,851
	9	2,619,161.1	1,833,494.0	185.9	10.6	62,017
	10	2,703,792.6	1,903,636.6	189.3	10.4	63,652

Хавсралт 2. Орон нутгийн банкуудын ипотекийн зээлийн тайлан

2014 оны 8 дугаар сарын байдлаар

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТТБХ-ийн зээл		Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХугацаа (сар)	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь			
1 Улаанбаатар	1,961,308.6	76.8%	1,326,971.4	74.5%	192.2	10.1	40931
2 Дархан-Уул	97,585.9	3.8%	81,901.5	4.6%	150.5	10.2	3,044
3 Орхон	88,776.8	3.5%	74,312.3	4.2%	176.5	9.5	2,524
4 Дорноговь	52,346.8	2.0%	41,190.9	2.3%	197.8	9.2	1,614
5 Сэлэнгэ	36,108.1	1.4%	27,081.3	1.5%	180.3	11.2	1,300
6 Дорнод	34,825.5	1.4%	30,658.5	1.7%	184.6	9.9	1,226
7 Өвөрхангай	31,782.6	1.2%	23,264.2	1.3%	151.5	12.6	1,213
8 Увс	29,934.2	1.2%	19,573.6	1.1%	184.6	15.8	1,102
9 Баянхонгор	28,444.7	1.1%	24,749.0	1.4%	183.9	9.5	744
10 Өмнөговь	27,368.6	1.1%	17,917.7	1.0%	158.2	15.4	810
11 Ховд	23,602.4	0.9%	18,934.8	1.1%	184.9	11.5	891
12 Баян-Өлгий	17,988.3	0.7%	8,545.5	0.5%	112.2	18.2	937
13 Сүхбаатар	17,248.7	0.7%	11,106.3	0.6%	127.7	15.6	662
14 Архангай	15,693.1	0.6%	12,029.3	0.7%	137.8	14.2	521
15 Говь-Алтай	14,985.3	0.6%	11,921.1	0.7%	161.4	9.8	504
16 Хөвсгөл	13,516.4	0.5%	6,624.1	0.4%	106.4	14.4	593
17 Завхан	12,780.8	0.5%	7,391.5	0.4%	127.7	19.2	422
18 Дундговь	10,492.4	0.4%	8,023.7	0.5%	190.6	11.3	345
19 Төв	10,311.3	0.4%	7,192.0	0.4%	153.6	13.6	377
20 Говьсүмбэр	9,890.7	0.4%	8,928.7	0.5%	230.8	7.7	358
21 Булган	9,706.0	0.4%	4,952.1	0.3%	120.7	16.5	389
22 Хэнтий	9,130.0	0.4%	6,808.7	0.4%	175.3	9.2	344
Нийт	2,553,827.2	100%	1,780,078.3	100%	186.7	10.5	60851

2014 оны 8 дугаар сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 76.8 хувийг Улаанбаатар хотод, 23.2 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 16.5 хувь буюу 97.6 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 15.0 хувь буюу 88.8 тэрбум төгрөг Орхон аймагт, 8.8 хувь буюу 52.3 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.